



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 612

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлага худалдааны талаар авах арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Улс хоорондын шуудан илгээмжийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хоёр удаагийн нээлттэй дуудлага худалдаагаар оролцогч ирээгүй, элэгдлээрээ өртгөө нөхсөн сэргээн засварлах боломжгүй 28,196,000.00 (хорин найман сая нэг зуун ерэн зургаан мянга) төгрөгийн балансын үнэ бүхий тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, харьяа байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг батлагдсан маягтын дагуу гарган 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

• 132006998

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021
оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 64 дугаар
тогтоолын хавсралт

Гаалийн ерөнхий газрын харьяа Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн
газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар дахин
худалдах тээврийн хэрэгсэл

№	Автомашинны марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын, Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Сэлбэг хэрэгсэлийн зардал /төгрөг/	ТӨБЗГ-ын 2021 оны 346 дугаар тогтоолоор тогтоосон үнэ /төгрөг/	Худалдах доод үнэ
1	Хьюндай Элентра маркийн, 53-35 УНУ улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар - KMHDU41BAAU035261	2010/2011	28,196,000.00	265,000.00	4,500,000.00	3,000,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		28,196,000.00 (хорин найман сая нэг зуун ерэн зургаан мянга)	265,000.00 (хоёр зуун жаран таван мянга)	4,500,000.00 (дөрвөн сая таван зуун мянга)	3,000,000.00 (гурван сая)